

Хэл соёлын цөм болох нь

Магистр Ц.Нямсүрэн, Магистр Т.Энхтунгалаг

Товч агуулга. Хэл бол биологи үндэстэй соёлын үзэгдэл юм. Хүний тархи, амны хөндий, хоолойн анатоми зэрэг нь соёлын хосгүй бүтээл болох хэлийг боломжтой болгодог. Гэхдээ хэл хэдийгээр соёлын бүтээл ч гэлээ эргээд соёлын, цөм, тулгуур болдог гайхалтай тогтоц билээ. Харин хэлний энэ тогтоц бүрэн бүтэн байж л соёлын найдвартай тулгуур болно. Хэлний тухай бодохдоо ихэнх хүн түүнийг зөвхөн яриа төдийхөн болгож ойлгох хандлага бий. Гэтэл хэл нь дуу авиа, яриа, бичиг гэх мэт өөр хоорондоо холбоотой ч ялгаж ойлгохоос өөр аргагүй функц, дадал, чадвараас бүрддэг. Хэл яриа нь сэтгэлгээг илэрхийлдэг, бичиг бол яриаг тэмдэглэдэг гэж зарим судлаач үздэг ч үнэн хэрэг дээрээ яриа, бичиг хоёрын нэгдсэн тоглолт хэлний хөгжлийг хангадаг ажээ. Бичиг, яриа хоёр язгуур онцлогоо хадгалж байж, хосгүй нэгэн хэлийг хамтдаа бүрэлдүүлнэ.

Түлхүүр үг: хэл, соёл, яриа, бичиг.

Соёл биднийг хосгүй нэгэн төрөл зүйл болгодог. Оршин байхуй нь сурсан зүйлээсээ үлэмж хамаардаг амьтан бол хүн юм. Биологийн хувьд генээр хүнд дамждаггүй боловч амьдралын явцад түүний олж эзэмшсэн, сурсан бүхэн соёлд хамаарна. Тэгэхээр биологийн төрөл зүйл болохын хувьд хүний оршин байхуй сурсан зүйлээсээ ихээхэн хамаардаг гэсэн үг. Иймд хүнийг биологи-соёлын амьтан¹⁶⁰ хэмээн онцлох нь бий. Уураг тархи, мэдрэлийн тогтолцоо, биеийн бүтэц зэрэг генээр тодорхойлогддог биологийн бүрдэл маань бидэнд соёлыг бүтээж, хэрэглэх боломж олгожээ. Биологийн эдгээр шинж онцлоггүйгээр хүмүүний соёл бидний мэдэх утгаар оршин байхгүй байсан. Гэхдээ хүний оршин байхуй сурч эзэмшсэн соёлын уламжлалаасаа хамааралтай. Биологийн шинж онцлог маань ихээхэн баялаг хэдий ч оршин байхуйнхаа наад захын хэрэгцээг автоматаар хангах зөн бидэнд байдаггүй. Иймээс хүний биологи, хүний соёл хоёр бие биенийхээ оршихуйд боломж олгодог ажээ.


Хэл бол биологи үндэстэй соёлын үзэгдэл мөн. Хүний тархи, амны хөндий, хоолойн анатоми бидний хэл яриаг биологийн үүднээс боломжтой болгоно. Нөгөө талаас хүний хэл бүхэн соёлын бүтээгдэхүүн билээ. Хэл бол символд утгачлагдан буудаг, сургалтаар дамжин нэг үеэс нөгөөд дамждаг, "ертөнцийн талаарх туршлагаа тэмдэглэн буулгаж, бусадтай хуваалцахын тулд хүн төрөлхтний хэрэглэдэг дурын дуун символуудын тогтолцоо"¹⁶¹ юм. Хүний хэл нь түүнийг амьдралын бусад төрөл зүйлээс ялгаж өгдөг хосгүй зүйл билээ. Хэл хүмүүсийг бие биетэй нь харьцах бололцоо өгдөг ч харилцаанд бас саад тотгор учруулдаг. Хэлний олон янз байдал энэ саадын нэг томруун жишээ юм.

¹⁶⁰ Emily Schultz, Robert Lavenda, *Cultural Anthropology: a perspective on the human condition* (California: Mayfield Publishing, 5th ed, 2001), p.4.

¹⁶¹ Ibid, p.80.



-Хэл яагаад байдаг вэ? Игнац.
-Бид бие биенээ ойлгох гэж хэлтэй байдаг.



-Тийм гэж үү?
-Тийм ээ.



-Чи Финн, Лэплэндэр, Ошкошэр хэлийг ойлгох уу, аан?
-Үгүй



-Финн, Лэплэндэр, Ошкошэр хэлийг ойлгодог уу?
-Үгүй ээ.



-Тэгвэл би хэл гэдэг чинь бие биенээ ойлгоход саад болдог гэж хэлэх байна.

Хэл нь үнэндээ бүх соёлын суурь¹⁶² гэдэгтэй санал нийлэхгүй байхын аргагүй. Гэхдээ хэл яагаад ийм чухал байр суурь эзэлдэг вэ? Зарим эрдэмтний үздэгээр хэл бол харилцааны хэрэгсэл төдийхөн биш ажээ. Тэрээр соёл, тэр бүү хэл сэтгэлгээнд маань нөлөөлдөг. XX зууны эхний хэдэн арван жилээс хэл шинжээч, антропологичид бодит байдлыг хүртэх хүртэхүйг маань тодорхойлоход хэл маш чухал үүрэгтэй хэмээн үзэх болов.

Энэ дүгнэлт хүрээлэн буй дэлхийгээ бид хэрхэн харахыг хэл урьдаас тодорхойлдог гэж хэлсэн Эдвард Сэпир, түүний оюутан Бэнжамин Ворф нартай гол төлөв холбоотой. Өөрөөр хэлбэл хэлний үйл нь бодит байдлыг шүүн тодруулдаг камерийн цуглуулагч линзтэй адил бөгөөд бид бодит ертөнцийг хэлнийхээ ойлголтуудаар л хардаг.

хүн —————> хэл —————> бодит байдал

Энэ таамаглалынхаа баталгаа болгож тэд өнгөний нэршил зэрэг зүйлсийн талаар соёл хоорондын харьцуулалт хийжээ. Нүд маань өнгийг мэдрэх үед бид цахилгаан соронзон цацаргалт өөрөөр хэлбэл үзэгдэх гэрлийг хүртдэг. Үнэндээ үзэгдэх гэрлийн спектр нь нэг туйлаас нөгөөд тасралтгүй хувиар өссөн давтамж бүхий гэрлийн тусгал юм. Тодруулбал, байгаль дээр улаан, ногоон гэх мэт өнгө хооронд зааг байхгүй.

Соёл маань хэлээр дамжуулан спектрийг өнгө хэмээн бидний нэрлэдэг, дурын байдлаар зохиосон категориор харахад хүргэдэг. Өөр соёлууд спектрийг өөр өөрөөр хуваадаг. Үүнийг өнгөний талаарх монгол хэлний зарим нэршилийг Нигэрийн Тиив хэлний тохирох өнгөтэй нь харьцуулсан байдлаас харж болно.

¹⁶² Richard Schaefer, *Sociology: a brief introduction*, McGraw-Hill, 5th ed, 2004, p.56.

	Монгол хэл	Тиив хэл
	Ногоон	и /тод өнгө/
	хөх	
	Саарал	
	хүрэн	пупу /бараан өнгө/
	Улаан	
	Шар	
		няиан

Сэпир, Ворф хоёр иймэрхүү баримт нь өнгө бол угтаа бодит байдлын нэг хэсгийг тодорхойлдог объектив зүйл биш гэдгийг илтгэж байна хэмээн тайлбарласан. Сэпир-Ворфын таамаглалыг дэмжихэд хэрэглэгдсэн энэ жишээг 1960-аад онд жинхэнэ утгаар шалгажээ. Энэ шалгалт тэдний дүгнэлт арай хатуудсаныг илрүүлсэн байна. Хэвийн бүх хүн өнгөний нэр томъёо хэл бүхэнд өөр байлаа ч өнгөний ижил сэрэл хүртэхүйтэй. Өөрөөр хэлбэл нүдний маань физиологи үндсэндээ ижил. Даян дэлхийн хүмүүс өнгөний илт ялгааг харж, үзэгдэх гэрлийн спектрийг өөр маягаар ойлгож чадна. Харин нийгмийн эдийн засаг, технологи нарийсан хөгжихийн хэрээр өнгөний нэр төрөл ч олширч байна. Тодруулбал, үзэгдэх гэрлийн спектр улам олон айд хуваагдах боллоо. Орчин өөрчлөгдөхийн хэрээр үүнийг тодорхойлохын тулд соёл, хэл хоёр шинэ нэр томъёо бий болгон хариу барьж байна.

Тухайн соёлд буй ойлголт, нэр томъёо юуны өмнө соёлын сонирхол, аж ахуйг илэрхийлдэг нь өнөө үед тодорхой болсон. Жишээ нь, Фрэнз Боазын дурдсанаар Эскимос хэлнээ цасыг үгийн язгуурын хувьд огт холбоогүй хэд хэдэн үгээр илэрхийлдэг байна: *апут* "газар дээр буй цас", *кана* "орж буй цас", *пиксирпок* "будран орох цас", *кимүксүк* "хунгарласан цас" гэх мэт. Мөн Канадын Баруун хойд нутгийн Индианчууд цасны янз бүрийн төлөв байдлыг ялгасан дор хаяж арван гурван нэр томъёог хэрэглэдэг бол цанаар гулгадаггүй уугуул Өмнөд Калифорничуудын ихэнх нь цас, мөс гэсэн ердөө хоёр нэр томъёо ашигладаг ажээ. Угтаа Англи хэлэнд усны хөлдсөн төлөвийг тэмдэглэдэг олон үг (жишээ нь, *blizzard, dusting, flurry, frost, hail, hardpack, powder, sleet, slush, snowflake*) байдаг боловч эдгээрийг халуун бүсийн хүмүүс төдий л хэрэглэдэггүйтэй энэ нь холбоотой. Монголчуудын хувьд амьдрал ахуйтайгаа уялдан мал аж ахуйтай холбоотой зүйлийг туйлын нарийн ялган нэрлэж чаддагийг энд дурдаж болно. Ганц жишээ дурдахад бид аргал, хоргол, өтөг, бууц, хөрзөн гэхчлэн нэг л зүйлийг янз бүрийн төлөв байдалд нь ялган нэрлэдэг. Иймэрхүү жишээ дурдвал дуусахгүй жагсаалт гарах бизээ.

Тодорхой зүйлд холбоотой нэр томъёо их бага ямар нэг хэмжээгээр жендэр гэх мэт хүчин зүйлээс бас хамаардаг. Жишээ нь, бүсгүйчүүдийн ихэнх нь өнгө ялгахдаа эрчүүдээс хавьгүй илүү байдаг байна. Энэ нь эмэгтэйчүүдийн хувцас, гоо сайханд өнгөний ялихгүй ялгаа ч чухал нөлөөтэй байдгаас үүдэж буй хэрэг билээ.


Хэл бол соёлын хамгийн чухал бүрдэл гэдэг нь хэнд ч маргашгүй илэрхий юм. Соёлын бүрийн ялимгүй ялгаа, гүн утгыг хэлийг нь сайн мэдэхгүйгээр ойлгох боломжгүй. /Аргалын утаа боргилсон Малчны гэрт төрсөн би Атар хээр нутгаа Өлгий минь гэж боддог гэсэн мөртөд илэрсэн утга санаа зөвхөн монгол хэл, соёлыг мэдэх хүний сэтгэлд хүрэх бизээ/

Хэл нь хүний харилцааны илэрхийлэл юм. Хэлээр дамжуулж мэдлэг, үнэлэмж, итгэл бишрэл, зан байдлыг мэдэрч, тайлбарлаж, хамтаар хүртэж байдаг.

Гэхдээ хэлний аль нэг шинжийг онцгойлон дөвийлгөх нь их эрсдэлтэй. Хэл бол харилцааны хэрэгсэл гээд хатуу баримтлавал хэл ертөнцийг зурагладаг гэдэг өмнөх баримтаас гадна өөр олон амьтан, тэр бүү хэл зарим ургамлын төрөл зүйл өөр хоорондоо харилцдаг тул хүмүүс бид энэ тал дээр хосгүй нь хараахан биш гэх мэт баримтыг хэрхэх вэ? Түүнчлэн хэлний тухай ярихтай зэрэг түүнийг зөвхөн яриа төдийхөн болгож ойлгох хандлага бий. Гэтэл хэл нь дуу авиа, яриа, бичиг гэх мэт өөр хоорондоо холбоотой ч ялгаж ойлгохоос өөр аргагүй функц, дадал, чадвараас бүрддэг.


Дуу авиа /буюу авиалбар/ нь хүн болон сүүн тэжээлтэн амьтад уушиг, дууны хөвчөө ашиглан бий болгож буй чимээ юм. Гэхдээ дуу авиа нь яриатай адил биш. Нялх хүүхдийн шулганах, хүний инээх, гэнгэнэх, уйлах, амьтны хуцах, мөөрөх, янцгаах, архирах цөм дуу авиа мөн, харин яриа биш. Дуу авиа маань гарны хээ шиг хосгүй байдаг нь бас сонирхолтой.

Хүн бодол санаа, мэдрэмж, сэтгэгдлээ бусад хүнд амаар илэрхийлэхдээ дуу авиагаар үүсч буй үндсэн өнгийг өвөрмөц, ойлгож болохуйц чимээ болгон өөрчлөн хувиргаж яриаг бүтээдэг байна. Философийн зарим сургаалд яриа нь бодит байдлыг тусган илэрхийлэгч сэтгэлгээг тэмдэглэдэг, бичиг нь яриаг тэмдэглэдэг хэмээн үздэг. Харин хэл шинжээч Фердинанд дэ Сюссор хэлний гол нэгж болсон тэмдэг нь тэмдэглэгч, тэмдэглэгдэгч хоёроос тогтоно гэж тайлбарласан.




Зураг. 1 - Тэмдэг /Сюссорын тайлбараар/

Тодорхой нэг тэмдгийг тодорхой нэг ойлголттой заавал холбох бодит шалтгаан байхгүй учраас тэмдэг нь дурын шинжтэй.



Зураг. 2 –Дурын шинж

Сюссор хэлийг нэр томъёоныхоо түрхэн зуурын цэгцрэлээс өөр юугаар ч тодорхойлогддоггүй цэвэр үнэлэмжийн тогтолцоо гэж үзсэн. Тэгээд тэрээр хэлийг диахрон буюу түүхэн хөгжилд (CDтэнхлэгт) нь гэхээсээ



хэлийг тухайн нэг цагт буй бүрэн гүйцэт тогтолцоо гэж авч үздэг синхрон байдлаар (АВ тэнхлэгт) судалсан. Энэ нь шатрыг диахрон байдлаар (буюу цагын аясаар дүрэм нь хэрхэн өөрчлөгдсөнийг) эсвэл синхрон байдлаар (одоогийн дүрмийг) судлаж болохтой ижил.

Зураг. 3 – Синхрон ба диахрон тэнхлэг

Түүний дэвшүүлсэн зарим санааг хожим Жак Дэррида шүүмжлэн хэлэлцсэн юм. Учир нь Сюссор зэрэг хүмүүсийн үзэл баримтлал бичгийг ярианаас үүсэлтэй хоёрдугаар зэргийн зүйл болгон хувиргасан ажээ. Үнэн хэрэгтээ тийм биш болохыг түүний бичсэн "Грамматологийн тухай" зохиол нь үзүүлнэ. Уг бүтээлд яриа, бичиг хоорондын харилцааг, бичиг, яриа хоёр хэрхэн хэлний хэлбэр болж хөгжсөнийг судалсан. Хэлний үүслийн талаарх философи болон шинжлэх ухааны олон судалгаанд тусгалаа олсон, ярианаас бичиг үүссэн гэдэг үзэлтэй Дэррида санал нийлдэггүй. Бичиг бол ярианы илэрхийлэл гэж үзэх нь утга, төсөөллийн үнэн буюу логосд яриа нь бичгээс илүү ойр гэсэн дүгнэлтэнд хөтлөх ажээ. Дэррида хэлний хөгжил нь яриа, бичгийн нэгдсэн тоглолтоор хэрэгждэгийг, иймд хэлний хөгжилд аль нэг нь илүү чухал гэж үзэх үндэсгүйг харуулсан.

Логос¹⁶³ нь хэл болоод философийн голлох зарчим мөн гэсэн хандлагыг логоцентризм гэдэг. Энэ нь бичиг биш яриа хэлэнд чухал гэсэн үзэл юм. Харин грамматологи¹⁶⁴ нь бичгийн тухай санааг ярианы тухай санаанд захируулахаас чөлөөлөх учиртай билээ. Логоцентрист онол ёсоор яриа бол утгын язгуур тэмдэглэгч, бичиг нь ярианаас урган гардаг. Логоцентризм үзэхдээ хэл нь яриаг төрүүлэгч сэтгэлгээний процесс болж үүссэн, яриа нь бичгийг бүтээдэг гэнэ. Утга санаагаа тэмдэглэгдэгч санаа буюу ойлголтоос олох тэмдэглэгчээс лингвистик тэмдэг бүрдэнэ гэсэн онол логоцентризмийг дэвэргэдэг. Логоцентризм тэмдэглэгчийг тэмдэглэгдэгчийн хувьд гадаад зүйл гэж үзнэ. Бичиг бол ярианы хувьд гадаад тал, яриа бол сэтгэлгээний хувьд гадаад тал гэх мэт. Гэвч бичиг нь яриаг тэмдэглэдэг юм бол бичиг нь тэмдэглэгчийн тэмдэглэгч байж таарна. Иймд логоцентризм ёсоор бичиг нь ярианаас утгаа авдаг хэлний дайвар хэлбэр ажээ. Ярианы ач холбогдлыг хэлний хөгжилд гол хэмээн логоцентризм онцолж, бичгийн ач холбогдлыг гадуурхадаг байна.¹⁶⁵

Тэмдэглэгч нь бусад тэмдэглэгчийн хувьд тэмдэглэгдэгчээсээ хамаарч гадаад, дотоод аль нь ч байж болно гэж Дэррида тайлбарлажээ. Логоцентризм яриаг дотоод, бичгийг гадаад тал гэж үздэг. Дэрридагийн үзлээр яриа, бичиг хоёрын ялгааны тоглоом нь гадаад, дотоод хоёрын ялгааны тоглоом юм. Бичгийг ярианы гадаад төлөөлөл гэж үзэх юм бол түүнийг бүрэн ойлгож чадахгүй. Бичгийн ач холбогдлыг бүрэн ойлгоё гэж байгаа бол логоцентризмийг хэрэгсэхгүй байх учиртай.

Гадаад, дотоод байдлын ялгааны тоглоом нь бичиг, яриа хоёр хэн хэнийхээ хувьд гадаа ч мөн, дотор ч мөн гэдгийг илрүүлсэн. Бичиг, яриа хоорондын ялгааны энэ тоглоом бас гадаад, дотоод байдал үгүй болж байгааг илтгэнэ. Иймд гадар, дотор гэдэг нь бичиг, ярианы аль алиныг нь тодорхойлж чадахгүй тохиромжгүй ойлголт юм.

Логоцентрист онол ёсоор яриа нь байхуйн нэг төрөл, учир нь яригч бол сонсогчийн хувьд яг байгаа зүйл, харин бичигч хүн бол уншигчийн хувьд яг

¹⁶³ үг яриа, бодол сэтгэлгээ, эмх цэгц, хууль, зүй тогтол, ухаан гэсэн утгатай грек үг

¹⁶⁴ бичгийн тухай шинжлэх ухаанд хамааруулж Дэрридагийн хэрэглэсэн нэр томъёо

¹⁶⁵ Jim Powell, *Derrida for Beginners*, (New York: Writers and Readers Publishing, 1997), p.23.

байгаа зүйл биш учраас бичиг нь байхгүйн нэгэн төрөл болно. Бичиг бол бичигч, уншигч хоёр байгааг орлодог зүйл. Хэрвээ уншигч, бичигч хоёр бэлхнээ зэрэгцээд байж байвал бичигч нь бичихийн оронд ярьж харилцах болно. Иймд логоцентризм бичгийг ярианы орлуулга, бичиг бол ярианы буй байдлыг ахин сэргээх ородлого гэж үзнэ. Логоцентризмыг Дэррида "чинагуух тэмдэглэгдэгчийн" төлөөх хүслээр өдөөгдсөн "байхуйн метафизик"¹⁶⁶ гэж тодорхойлжээ. "Чинагуух тэмдэглэгдэгч" бол бүх тэмдэглэгчийн цаана байгаа тэмдэглэгдэгч юм.

Байхуй, үл байхуйн үүслийг тодорхойлохын тулд Дэррида "differance" гэсэн нэр томъёо ашигласан. Үүнийг "байхуйн метафизикээр" тайлбарлаж болдоггүй. Франц хэлнээ уг нэр томъёо "хойшлуулах", "ялгах" гэсэн хоёр утгыг зэрэг илтгэдэг. Иймд энэ нь хойшлогдсон төлөв байдал төдийгүй, ялгаатай байх төлөв байдал юм. "Differance" бол байхуй, үл байхуй хоёрт харш зүйл хэмээн Дэррида тайлбарласан байдаг.¹⁶⁷ Энэ нь яриа, бичиг хоёрын, дотоод утга, гадаад төлөөлөл хоёрын "нугас" бас мөн.

"Өвөг бичиг" хэмээх нэр томъёог Дэррида "байхуйн метафизикийн" хүрээнд томъёолж болохгүй хэлний нэг төрөл хэлбэрийг тодорхойлохын тулд хэрэглэжээ. Энэ бол ярианаас үүсээгүй, хэлний язгуур нэгэн хэлбэр юм. "Өвөг бичиг" бол яриа, бичиг хоёрын ялгаанаас болж гацдаггүй нэгэн төрөл хэл билээ. Энэ бол хэлний бичгийн болон бичгийн бус хэлбэр хоорондын ялгааны тоглоомын нөхцөл мөн. Дэррида "өвөг бичгийг" бичгийн талаарх "бүдүүлэг" ойлголттой харьцуулж, "байхуйн метафизикийн" дэвшүүлдэг бичгийн бүдүүлэг ойлголтыг "өвөг бичгийн" ойлголт эвдэж бүтээлээ"¹⁶⁸ гэжээ.

Бичиг байгаагийн гол зорилго нь яриаг тэмдэглэх явдал гэж хэлсэнийнх нь төлөө Сюссорыг Дэррида шүүмжилсэн. Сюссорын хэл шинжлэлээр бол ярианы хэлний артикуляци нь санааг авиа-имижтэй холбох механизм /Дэрридагийн нэрлэдэгээр нугас/-с хамаарна, бичгийн хэлний артикуляци бичсэн үгийг ярианы үгтэй холбох механизмаас хамаарна. Дэррида Сюссорын хэлний онолыг логоцентризм, фоноцентризм аль алинд далим болсон гэж шүүмжилсэн. Дэррида бичгийг авиан ч байж болно, биш байж болно гэж маргадаг. Авиан бус бичиг нь зурагт, дүрст, тэмдэгт байж болох бичиг байж болно. Бичиг нь дуу авианы түр зуурын шинжид захирагдахгүй олон хэмжээст бүтэцтэй байж болох юм.¹⁶⁹ Дуу авианы шугаман биежилт болсон бичгийг нэгэн төрөл байхуйн задгайралт гэж томъёолж болно. Сюссор ярианы хэл бол санааг авиа-имижтэй холбодог үйл ажиллагаа гэж заадаг бол Дэррида ганц авиан тэмдэглэгч олон тооны авиан үнэлэмжтэй, эдгээр авиан үнэлэмж нь олон янзын хувилбартай байж болно гэж тайлбарладаг.

"Грамматологи" бол Сюссорын дэврээсэн ярианы ба бичгийн хэлний харилцааны талаарх онолыг эвдэн бүтээж, бичгийн жинхэнэ символик хүчийг хайн шинжилсэн.

Бичиг бол ярианы нэмэлт гэсэн Руссогийн онолыг судлахын тулд хэлний үүслийн талаарх Руссогийн "Бодрол"-д Дэррида дэлгэрэнгүй тайлбар өгсөн. Бичиг бол юу ч биш, гэхдээ яриаг тэмдэглэдэг гэж Руссо хэлсэнийг тэрээр

¹⁶⁶ Jacques Derrida, *Of Grammatology*, translated by Gayatri Chakravorty Spivak (Baltimore: The Johns Hopkins University Press, 1974), p.49.

¹⁶⁷ Ibid., p. 143.

¹⁶⁸ Ibid., p. 60.

¹⁶⁹ Ibid., p. 85

шүүмжлэв. Тэрээр бичгийн үүрэг нь ярианы байхуйг орлох, орхигдсон, хаягдсан байхуйг сэргээх оролдлого, төдийхөн биш гэж тайлбарласан.

Руссогийн хэлсэнээр бичгийг ярианы орлуулга болгон хэрэглэвэл “аюултай нэмэлт” болж мэднэ. Бичиг нь ярих гэж байсан утгыг оргүй болгож магадгүй. Иймд Руссо бичиг бол хэлний уг мөн чанарыг завхаруулж мэднэ гэж үзсэн.

Харин Дэррида хэрвээ бичгийг ярианы нэмэлт гэж үзэх юм бол тэрээр ярианд утга нэмдэг, тэгэхээр байхуйн нэгэн төрлийг хангаж байна. Түүнчлэн бичгийг ярианы нэмэлт төдий гэж үзвэл энэ бол ярианд гадаад нэмэлт л болох билээ.

Бичиг бол ярианы нэмэлт гэсэн үндэслэл нь бичгээр нэмэгдэх ёстой ахуй ярианд гээгддэг гэдгийг давхар илтгэнэ. Ярианы байхуйн хүрээнд үл байхуй тэлж байвал бичиг байхуйд оргүй буй зүйлийг сэхээх хэрэгсэл болно гэсэн үг. Иймд бичгийг дан ганц үл байхуй гэж үзэж болохгүй. Энэ нь яриаг дан ганц байхуй гэж үзэж болохгүйтэй нэгэн адил юм. Яриа бичиг дотор илэрч болно, бичиг яриан дотор илэрч болно.

Дээрх бүхнээс бид бичиг бол хэлэнд ярианы нэгэн адил чухал үүрэгтэйг олж харна. Ер нь хэлийг яриа, бичиг гэсэн тулгуур хоёр баганатай, соёлын цөм хэсэг хэмээн үзэж болох юм. Иймд эх соёлоо хадгалж, хамгаалахын тулд юуны өмнө хэлний чухал бүрдэл болох бичиг, яриа хоёрыг эн тэнцүү анхааран үзэж хэлний бодлогоо томъёолох шаардлагатай ажээ. Хэлний бүтэц нь сэтгэлгээний бүтцийг тодорхойлдог гэсэн структуралист сургаал бий. Энэ бол хэл, сэтгэлгээ хоёрын хамаарлыг илтгэсэн сонирхолтой сургаал бөгөөд эндээс бид хэл эвдрэвэл сэтгэлгээ эвдрэнэ гэсэн далд санааг ухаарч болно.

Сүүлийн жилүүдэд монгол хэл маш их эвдэрч, зэрэмдэг болж байгааг хэдхэн цагийн дотор телевизийн хөтөлбөрийг үзэж суугаад батлаж болохоор болжээ. Зөвхөн зар мэдээний хэсгээс нь хаана ямар бараа худалдаж байгааг бус, харин худалдаалагдаж байгааг мэдэх болно. Ийм жишээг хэдэн зуугаар нь дурдаж болох ба энэ нь гадаад хэлний дүрмийн бүтцээр монгол хэлээ эвдэж байгааг илтгэх, үүнийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр өргөн олонд сурталчилж буй харамсалтай үзэгдэл билээ. Муу дээрээ муухай, муухай дээрээ улцан гэгчээр язгуур бичгээрээ бичиж чадахаа больчихоод дээр нь бас гадаад хэлний дүрэмд захируулан монголоор ярьдаг болж байгаа юм байна гэсэн гунигтай бодол төрж байдгаа нуух юун.

Ашигласан ном

1. Emily Schultz, Robert Lavenda. Cultural Anthropology: A Perspective On the Human Condition. California: Mayfield Publishing; 2001.
2. Jim Powell. Derrida for Beginners. New York: Writers and Readers Publishing; 1997
3. Jacques Derrida. Of Grammatology. Baltimore: The Johns Hopkins University Press; 1974
4. Richard Schaefer. Sociology: A Brief Introduction. New York: McGraw-Hill; 2004